



ТАИ ТЕСТИЙН ТАНИЛЦУУЛГА


THE SCIENCE OF PERSONALITY
SELECTION & DEVELOPMENT





ГАРЧИГ

1. Танилцуулга
2. Зан төлвийн тест /TAIP/
3. Чадамжийн тест /TAIAT/
4. Үйлчилгээ
5. Хариу тайлан




WELCOME



THE SCIENCE OF PERSONALITY SELECTION & DEVELOPMENT





TALENTS ASSESSMENT INSTITUTE бол сэтгэлзүйн ухааны судлаач, мэргэжилтнүүдээс бүрдсэн, хүний нөөцийн сонгон шалгаруулалт, үнэлгээ, сургалт хөгжил, байгууллагын хөгжлийн салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд БНСУ төдийгүй Азид хүчин төгөлдөр, шударга эрх тэгш сонгон шалгаруулалтын тогтолцоог бий болгоход төстийн хэрэглээг өргөн нэвтрүүлэх зорилго бүхий байгууллага юм.

▶ Сонгон шалгаруулалт

Шинэ төгсөгч болон туршлагатай ажил горилогчийг сонгон шалгаруулахад зөвлөгөө өгч сонгон шалгаруулалтын аргачлалаар хангана.

▶ Үнэлгээ

Тушаал дэвшүүлэх ажилтан, алба хэлтсийн даргын сонгон шалгаруулалтад зөвлөх үйлчилгээ үзүүлж аргачлалаар бүрэн хангана.

▶ Сургалт

Ажилтнуудын цогц үр чадварыг хөгжүүлэх, манлайлах үр чадварыг хөгжүүлэх сургалт явуулна.

▶ Байгууллагын хөгжил

Байгууллагын соёлыг оношилж баг бүрдүүлэлтийн сургалт явуулна.

TALENTS ASSESSMENT INSTITUTE нь өдгөө 10 гаруй жилийн туршид сэтгэлзүйн тест боловсруулж сонгон шалгаруулалтын кейс судалгаа явуулж ирсэн арвин туршлага дээрээ үндэслэн ЗАН ТӨЛВИЙН ТЕСТ (TAI-PI, TAI Personality Inventory) болон ЧАДАМЖИЙН ТЕСТ (TAI-AT, TAI Aptitude Test)-ийг боловсруулан гаргасан билээ.

TAIPI

Зорилго: Гүйцэтгэлд, дасан зохицолд эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх зан хандлагын хүчин зүйлсийг оношилно.

Юуг тодорхойлох вэ?: Ажлын байранд энгийн үед илрэх зан авир, стресстэй буюу хэвийн бус үед илрэх зан авирыг тодорхойлно.

433 асуултай



TAIAT

Зорилго: Гүйцэтгэл, ажлын ур чадварт шууд нөлөө үзүүлдэг ур чадварын хүчин зүйлсийг оношилно.

Юуг тодорхойлох вэ?: Ажлын гүйцэтгэлд нөлөөлдөг оюуны суурь чадамжийг тодорхойлно.

3 хэсэгтэй (хэсэг тус бүр 30 асуултай)





TAI төстийн онцгой давуу тал бол олон талын үнэлгээ хийх боломжтой, хүчин төгөлдөр байдал, бодит байдал, шударга эрх тэгш байдал нь өндөр үзүүлэлтэй нотлогдсон, эдийн засгийн хэмнэлттэй тул сонгон шалгаруулалтын маш үр дүнтэй аргачлал юм.

ЗАН ТӨЛӨВ БА ЧАДАМЖИЙГ ОЛОН ТАЛААС ХАРЖ ДҮГНЭДЭГ

TAIPI нь энгийн зан төлөв ба үл нийцэх зан төлвийн үзүүлэлтүүдийг олон өнцгөөс тодорхойлдог байхад TAIAT нь 3 төрлийн чадамжийн үзүүлэлтээр тодорхойлдог. Мөн 2 янзын оношлогооны аргачлалтай хамт ашиглавал сонгон шалгаруулалтын оношлогоог илүү нарийвчилсан түвшинд хийх боломжтой.

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ НЬ БҮРЭН НОТЛОГДСОН

10 гаруй жилийн олон судалгааны үр дүнд уг төстийн хүчин төгөлдөр байдлыг бүрэн баталгаажуулж мөн Монгол улсад хэрэгжүүлсэн судалгаагаар хүний нөөцийн сонгон шалгаруулалтын зах зээлд тохирох стандартыг тогтоосон болно.

БОДИТОЙ, ШУДАРГА ЭРХ ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРЭН ХАНГАСАН

Танил тал, нутаг усны харъяалал зэргээр ажилд авдаг шударга бус сонгон шалгаруулалт-ын тогтолцоог халж, шалгарсан шилдэг боловсон хүчнүүдэд тухайн байгууллагад итгэх итгэл, бахархах сэтгэлийг төрүүлж үл тэнцэгсдэд өөрийгөө хүлээн зөвшөөрч улам хичээх сэдлийг төрүүлнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМНЭЛТЭЙ

Төстийг онлайнгаар болон цаасаар авах боломжтой тул ажил горилогчдыг үнэлж дүгнэхэд зарцуудаг цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.



TAI нь шинэ төгсөгч, туршлагатай ажилтныг сонгон шалгаруулах тест, гүйцэтгэх удирдлагуудын сонгон шалгаруулалт болон цогц үр чадварын үнэлгээ, олон талын оношлогоо, оношлогоонд суурилсан манлайллын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах зэрэг маш өргөн цар хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.

ASSESSMENT for

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- Шинэ төгсөгч СШ-ын тест
- Туршлагатай ажилтан СШ-ын тест
- Мэргэжлийн ажилтан СШ-ын тест
- Тусгай мэргэжилтэн СШ-ын тест
- Нэгжийн удирдлагын СШ-ын тест
- Гүйцэтгэх дээд түвшний удирдлагын СШ-ын тест

ТОМИЛГОО

- Ажлын байрны шинжилгээ, судалгаа
- Ажил үүрэгтээ тохирох эсэх тест
- Ажлын байр сэлгэх, хөрвөх тест
- Хандлага тодорхойлох тест

КАРЬЕР ТӨЛӨВЛӨЛТ

- Career Building тест(хувь хүн)
- Management Building тест (удирдлага)

ҮНЭЛГЭЭ

- Цогц үр чадварыг оношлох тест
- Оношлогооны үр дүнд суурилан үр чадварыг дүгнэх ярилцлага(BEI)

МАНЛАЙЛАЛ

- Манлайллыг тодорхойлох тест
- Манлайллыг хөгжүүлэх хөтөлбөр
- Көүчинг хөтөлбөр
- EQ манлайллыг тодорхойлох тест
- Манлайллын олон талт оношлогоо

БАГ ХӨГЖҮҮЛЭЛТ

- Team Discovery тест
- Team Discovery W/S



TAI-ийн сонгон шалгаруулалтын төстийг зорилгоосоо хамаарч төрөл бүрээр бүрдүүлэн ашиглаж болно.

ТЕСТИЙН ТОЙМ			
СШ-ын төст	Тодорхойлох зүйл	Асуулт	Хугацаа
TAIAT	Чадвар, чадамж (Оюуны чадамж, ажлын чадвар гэх мэт)	3 хэсэг (нийт 90 асуулт, хэсэг тус бүр 30 асуулт)	90 минут
TAIPI	Энгийн зан төлвийн үзүүлэлт (Ажилтны загвар, цөм үнэт зүйл, цөм ур чадвар гэх мэт)	433 асуулт	50 минут
	Үл нийцэх зан төлвийн үзүүлэлт (Байгууллагад дасан зохицох чадварыг тодорхойлох)		

СОНГОН ШАЛГАРУУЛАХ ОБЪЕКТООС ХАМААРЧ САНАЛ БОЛГОХ НЬ

	TAIPI		TAIAT
	Энгийн зан төлөв	Үл нийцэх зан төлөв	
Шинэ төгсөгч	⦿	⦿	⦿
Туршлагатай ажилтан	⦿	⦿	△
Тусгай мэргэжилтэн	⦿	⦿	⦿
Мэргэжилтэй ажилтан	⦿	⦿	⦿
Удирдлага	⦿	⦿	△

⦿ = Маш хэрэгцээтэй, ⦿ = Хэрэгцээтэй, △ = Шаардлагатай бол

THE SCIENCE OF PERSONALITY
SELECTION & DEVELOPMENT

TAIRI төстээр байгууллагад ажиллахад, тухайн ажилд тохирсон зан төлөвтэй хүн үү үгүй юу гэдгийг тодорхойлдог бөгөөд ажил горилогчийн үйлдлийг таамаглан тухайн байгууллагад тохирох хүн нь аль вэ гэдгийг ялган таних боломжтой.



ТАИРИ ӨНДӨР ОНООТОЙ ХҮМҮҮСИЙН ОНЦЛОГ



- Зорилго нь тодорхой, маш үнэнч.
- Сэтгэл хөдлөлийн хувьд тайван, амархан уурладаггүй.
- Өөртөө итгэх итгэл, эрч хүч үргэлж оргилж байдаг, бусадтай харилцаа үүсгэх, харилцаагаа хадгалахдаа маш гаргууд.
- Шинэ зүйлд нээлттэй ханддаг, өөрчлөлтөд амархан дасан зохицдог.
- Аливаад дүн шинжилгээ хийдэг, тууштай.
- Шинэ мэдлэг олж авах гэсэн эрмэлзэл, сэдэл нь маш хүчтэй.
- Бусдыг халамжилж санаа тавьдаг.
- Урьдчилан төлөвлөж бүх зүйлд нухацтай ханддаг.



ТАИРИ БАГА ОНООТОЙ ХҮМҮҮСИЙН ОНЦЛОГ

- Бүх зүйлд идэвхигүй, дүрэм журмыг баримталдаггүй. Амархан сэтгэл хөдөлж уурлаж бухимддаг.
- Бусдаас урьтаж ямар нэг зүйл хийх дургүй. Өөрчлөлтөөс илүү одоогийнхоо нөхцөл байдлыг хадгалах дуртай.



- Шинэ зүйл мэдье суръя гэж зорьдоггүй, онолоос илүү практик талыг онцолдог. Мэдээллийн баазад ач холбогдол өгдөггүй, шууд өөрийн бодсоноор үйлддэг.
- Хувийн ашиг сонирхолоо байгууллагынхаас илүүд үздэг. Ажилдаа дургүй.
- Олон ажлыг зэрэг гүйцэтгэхэд бэрхшээлтэй. Хэл яриа, үйлдэл нь ихэнхдээ шууд дайрч давшилсан өнгө аястай.

Зан төлвийн тухай ойлголт

Зан төлөв гэдэг нь үнэт зүйл, үзэл бодлын хэв маяг, чин сэтгэл, хандлага, сэдэлжилт гэх мэт өргөн хүрээг хамарсан ойлголт юм.




ЗАН ТӨЛВИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Аливаа орчны харилцан үйлчлэлийн явцад харьцангуй нийцтэй илэрдэг хувь хүний онцгой зан чанар, үнэт зүйлс, сонирхол, сэдэлжилт

ЗАН ТӨЛВИЙН ОНЦЛОГ

- Хувь хүний өвөрмөц шинж, өөрөөр хэлбэл хүмүүсийг хооронд нь ялгаатай байлгадаг
➡ хүмүүс хоорондын ялгаа
- Олон янзын нөхцөл байдалд ижил төстэй илэрдэг үйлдэл, оюун санааны хэв маяг
➡ үйлдлийн зохицол
- Орчин нөхцлийн харилцан үйлчлэлд дасан зохицох чадварын тодорхойлолт
➡ Асуудалтай үйлдлийн шалтгаан

ЗАН ТӨЛӨВ НЬ НҮДЭНД ХАРАГДААГҮЙ, ХЭМЖИН ТОДОРХОЙЛОХОД БЭРХ БОЛОВЧ ХҮМҮҮСИЙН ӨӨР ӨӨР ҮЙЛДЭЛ, БАЙДАЛ ГАРГАДАГИЙН ГОЛ ШАЛТГААН БӨГӨӨД, ҮР ЧАДВАРЫН ИХЭНХ ХУВИЙГ ЭЗЭЛДЭГ МАШ ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛ



TAIPI гэдэг нь тухайн байгууллагад болон ажил үүрэгтээ тохирох эсэх бие хүний зан төлвийн үзүүлэлтийг тодорхойлдог тест юм.

TALENT ASSESSMENT INSTITUTE PERSONALITY INVENTORY

01

TAIPI ГЭДЭГ НЬ?

TAI-аас хамгийн анх боловсруулсан, энгийн зан төлвийн үзүүлэлт болон үл нийцэх зан төлвийн үзүүлэлтийг ОУ-ын стандартад тохируулан тодорхойлдог тест юм.

02

АСУУЛТ/ХУГАЦАА

433 асуулт/50 минут

03

ТЕСТИЙН ХЭЛБЭР

Интернетэд суурилсан онлайн тест, мөн цаасаар авч болно.



TAIPI нь бие хүний зан чанарын гэгээтэй (энгийн зан төлөв) болон бараан (үл нийцэх зан төлөв) талыг олон өнцгөөс тодорхойлохоор зохиогдсон бөгөөд нийт 12 үзүүлэлт (энгийн 7, үл нийцэх 5)-ээс бүрдэнэ.



- Ажлын гүйцэтгэл, харилцаанд нөлөөлөх үр чадвар ба зан чанарын үзүүлэлтийг тодорхойлно.
- Шинэ төгсөгч, туршлагатай ажил горилөгч, тушаал дэвшүүлэх ажилтны сонгон шалгаруулалтаар байгууллагын “ажилтны загвар”-тай тохирч буй хүнийг ялган таних боломжтой.
- Манлайлал, баг бүрдүүлэлтийн сургалтанд ажилтныг болон багийг оношлох аргачлал болгон ашиглана.
- Байгууллагад ажиллахад гарч болзошгүй үл нийцэх зан төлвийн үзүүлэлтийг тодорхойлно.
- Сонгон шалгаруулалтад байгууллагад хохирол учруулах эрсдэлтэй байж болох хүнийг урьдчилан шалгах боломжтой.

ТАИРI нь зан чанарын эерэг, сөрөг талыг тодорхойлдог. Үүгээрээ далд байгаа, өндөр гүйцэтгэлтэй байж болох хүнийг олж илрүүлэн мөн нуугдмал оршиж буй байгууллагад үл нийцэх хүнийг илрүүлэх боломжтой.



Энгийн зан төлөв


Ажлын гүйцэтгэл
сайжрах эсэхийг
таамаглан
ТОГТООНО.



select-in

Үл нийцэх зан төлөв

Ажлын гүйцэтгэл
буурах, үл
нийцэх, дасан
зохицохгүй
байх эсэхийг
таамаглан
ТОГТООНО.




screen-out




TAIPI тестийг хэрэглэж буй ААНБ-ын ажилтнуудаас хүчин төгөлдөр байдлын судалгаа авахад хүчин төгөлдөр байдал нь бүрэн баталгаажин аль ч байгууллагад тохиромжтой хэмээн гарсан болно.

Жишээ 1 Энгийн зан төлвийн үзүүлэлт



Үр дүн 1. Сайн гүйцэтгэлтэй ажилтнуудын оноо муу гүйцэтгэлтэй ажилтнуудынхаас өндөр гарсан.
Үр дүн 2. Үнэнч байдал өрсөлдөх чадвар, өөдрөг үзэл зэрэг нь маш чухал нөлөө үзүүлж байна.
Үр дүн 3. Нээлттэй байдал нь ажлын гүйцэтгэлтэй тийм ч их холбоотой биш. (Жич: Тухайн байгууллага үйлдвэрлэлийн чиглэлээр үа явуулдаг)

Жишээ 2 Үл нийцэх зан төлвийн үзүүлэлт



Үр дүн 1. Муу гүйцэтгэлтэй ажилтнуудаас үл нийцэх зан төлвийн оноо өндөр гарсан ажилтнуудын харьцаа сайн гүйцэтгэлтэй ажилтнуудынхаас их гарсан.
Үр дүн 2. Нэг бус олон үзүүлэлт ашиглах нь таамаглалын оновчтой байдлыг нэмэгдүүлж байна.

THE SCIENCE OF PERSONALITY
SELECTION & DEVELOPMENT



ТАИАТ тестээр ажил гүйцэтгэхэд шаардлагатай чадварыг эзэмшсэн эсэхийг тодорхойлдог бөгөөд ажил горилогчийн гүйцэтгэл ямар байх вэ гэдгийг таамаглан тухайн байгууллагад тохирох хүнийг ялган таних боломжтой.

ТАИАТ ӨНДӨР ОНООТОЙ ХҮМҮҮСИЙН ОНЦЛОГ

- Дээд албан тушаалтныхаа зааврыг маш сайн ойлгож хүлээж авдаг.
- Ажлын тайлан тавих, хурал хийхэд өөрийн санааг логиктой илэрхийлнэ.
- Албан бичиг, гэрээний гол агуулгыг зөв олж хардаг.
- Тоон мэдээлэл бүхий баримт материалыг зөв ойлгодог.
 - Өгөгдсөн нөхцөл байдлыг тоон үзүүлэлтэд хувирган илэрхийлж асуудлыг шийдэхэд ашигладаг.
 - Албан баримтын бүдүүвч, график бүхий материалыг зөв ойлгодог.
 - Өгөгдсөн материалыг туйлын зөв ойлгож өөр бусад салбарт ашиглаж болохоор хялбархан хөрвүүлэн хувиргах чадвартай.



ТАИАТ БАГА ОНООТОЙ ХҮМҮҮСИЙН ОНЦЛОГ

- Зааврыг бүрэн ойлгодоггүй, уялдаа холбоогүй шал өөр юм хийдэг.
- Эмх цэгцгүй ярьдаг, хэрэгцээгүй, гоё сайхан юм ярьж явдаг.
- Бичгээр өгүүлсэн зүйлийн агуулгыг бүрэн ойлгодоггүй, гүйцэтгэсэн ажил нь байнга дутуу дулимаг.
- Тоон мэдээллийг ойлгох, түүнийгээ бусадтай хуваалцах зэрэгт бэрхшээл учирна.
- Нөхцөл байдлыг зохицуулах тоон үзүүлэлттэй холбоотой гарах арга замыг олж харж чаддаггүй.
- Өгөгдсөн материалыг ойлгохдоо муу учир хамт ажиллагсад, удирдлагаасаа байнга түүнийгээ асууж лавлана.
- Өөрийн салбарт ашиглагдааг материалыг муу ойлгодог тул бусад салбарт хөрвүүлэх чадваргүй.



Чадамжийн
тухай
ойлголт

Чадамж гэдэг нь оюуны чадамж мөн үр чадвараас өөр ойлголт бөгөөд ажил мэргэжлийн орчинд шаардлагатай чадвар юм.

ОЮУНЫ ЧАДАМЖ (INTELLIGENCE ABILITY)

Binet: Шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадвар

Wechsler: Зорилго бүхий үйлдэл хийдэг, логиктой бодож сэтгэдэг, чадварлагаар бүх зүйлийг зохицуулдаг цогц чадвар

ЧАДАМЖ (APTITUDE)

Эрдмийн салбар, ажил мэргэжлийн салбарт тухайн хүний чадвар тохирч нийцэж буй эсэх (Ажил үүрэгт шаардаж буй чадвар, тухайн хүний чадвар хоёрын зөрүү)

ҮР ЧАДВАР (COMPETENCY)

McClelland(1973): Аливаа ажил үүргийг амжилттай гүйцэтгэхийн тулд шаардлагатай мэдлэг, чадвар, чадамж болон бусад онцлог шинж

Voyatzis(1982): Аливаа ажил үүрэгт хамгийн сайн тохирох нөөц шинж чанар





TAIAT нь ажил гүйцэтгэх үр чадварыг тодорхойлдог чадамжийн тест буюу бичгийн шалгалт юм.

TALENT ASSESSMENT INSTITUTE APTITUDE TEST

01

ТАИАТ ГЭДЭГ НЬ?

TAI-аас боловсруулсан 2 дахь тест, ажлын гүйцэтгэл, чадварыг тодорхойлох тест юм.

02

АСУУЛТ/ХУГАЦАА

Хэсэг тус бүр 30 минут (Ерөнхий 3 хэсэгтэй)

03

ТЕСТИЙН ХЭЛБЭР

Цаасаар авна.



TAIAT тест нь ерөнхийдөө чадамжийн тест мөн мэргэжлийн шалгалт гэж ойлгож болно. Сонгон шалгаруулалтаар дүгнэгдэх мэргэжлийн чадвар гэдэг нь туршлагатай ажилтны хувьд ижил төстэй ажил гүйцэтгэж байсан бодит туршлагыг хэлнэ, харин шинэ төгсөгчийн хувьд тухайн ажилд томилогдох болбол гүйцэтгэх ажил үүргээ ойлгож хамгийн сайн гүйцэтгэлтэй байх чадварыг хэлж байгаа тул “оюуны чадамж” нь ажлын гүйцэтгэлийн стандарт болно.

Ажил, мэргэжлийн чадамжийн тест нь хэлний чадвар, тооцоолол бодох чадвар, таамаглан дүгнэх чадвар зэрэг үндсэн, цөм оюуны чадвар, чадамжийг тодорхойлдог бөгөөд тухайн байгууллагын чухалчлан үздэг оюуны чадамжийг нэмж оруулж болно.



Хэсэг	Ангилал	Тестийн агуулга	Асуултын тоо	Хугацаа
Хэлний чадвар	Хэл яриаг ойлгох, текст дээр ажиллах	Хэл ярианы утгыг ойлгож, зорилгод нийцсэн хариулт өгч, өөрийгөө зөв илэрхийлж буй эсэхийг дүгнэх	30	30 мин
	Таамаглан дүгнэх	Хэлээр илэрхийлэгдэж буй мэдээлүүдээс тодорхой зүйлийг таамаглан, магадлал сайтай дүгнэлт гаргах чадварыг дүгнэх		
Тооцоолон бодох чадвар	Баримт, материал ойлгох	Бүх төрлийн бүдүүвч, тойм (хүснэгт, диаграм, зураг, тайлбар гм) материалыг богино хугацаанд зөв ойлгох чадварыг дүгнэх	30	30 мин
	Хэрэглээний тооцоолол	Ажил дээр гарах тооцоолон бодох, хариу гаргах чадварыг дүгнэх		
	Дарааллыг олох	Өгөгдсөн тоонуудын дэс дараалал, харьцаа зэргийг олж тогтоох чадварын дүгнэх		
Орон зайн мэдрэмж, чадвар	Оронзайн мэдрэмж	Байгууллагын зурган үзүүлэлтүүдээс үйл ажиллагааны түвшин, чиглэл гм явцын өөрчлөлтийг харж ойлгох, илэрхийлэх чадварыг дүгнэх	30	30 мин
	Зурган материал дээр ажиллах	Зураг, диаграммын дараалал, өөрчлөлтийн харьцаа, зарчим зэргийг таамаглан олох чадварыг дүгнэх		


ТАИАТ-ын хүчин төгөлдөр байдлыг шалгах кейс судалгаа хийхдээ ТАИ-ын хэрэглэгч байгууллагын ажил горилогчдоос төгссөн сургуулийн түвшингөөр мэргэжлийн шалгалт авч дүнгийн дунджийг харьцуулж үзэв. Хувь хүний оноо их сургуулийн рейтингээс хамаарахгүй байж болох ч, дундаж оноо нь төгссөн сургуулийн рейтингтэй пропорциональ дүн гарав.




Хүчин
төгөлдөр
байдлын
судалгаа

Сургуулийн рейтингээр мэргэжлийн шалгалтын онооны дунджийн харьцуулалт


Хэлний чадвар




Материал ойлгох чадвар




Асуудал шийдэх чадвар



Таамаглах чадвар



Орон зайн мэдрэмж




“ Сургуулийн рейтинг
2013

БНСУ-ын их дээд
сургуулиудын
нэгдсэн үнэлгээгээр
тогтоосон шалгуурын
дагуу ангилав.

”

THE SCIENCE OF PERSONALITY SELECTION & DEVELOPMENT



TAIPI тестийг онлайнаар болон цаасаар хоёулангаар нь өгөх боломжтой байдаг бол TAIAT тест нь зөв хариулттай тест учир зүй бус үйлдэл гарахаас сэргийлэх үүднээс ихэнх тохиолдолд цаасаар авдаг. Харин шалгалт өгөх хүний тоо цөөн байвал хянагч ажилтныг байлцуулан онлайнаар өгч болно.

Онлайн тест өгөх процесс



Тест өгөх хүмүүсийг бүртгэх

- Бүртгэлийн маягтад нэрсийг оруулах
- Оролцогчдын нэр, код бүхий листийг хүлээн авах



Тест явагдах заавар өгөх

- Хүн бүрд мейл явуулах
- Мессеж явуулах

Асуулт бүртгэх

- Заавар өгөхдөө сонирхсон асуултуудыг бүртгэх, хариу өгөх



Тестийн явцыг байнга мэдээлэх

Тестээ өгөөгүй байгаа хүмүүст дахин мейл, мессеж явуулах

Trouble Shooting

Гацааг гаргах

Шалгалт өгөх хүн цөөн бол хянагч ажилтан хамт байх



Тест авах хугацаа дуусахад сайтаа хаана

Data-г бүхэлд нь шалгах

Репорт гаргаж явуулах

Цаасаар тест өгөх процесс



Ангилал	Шалгалт авах байгууллага	Шалгалт авах газар	Тайлан илгээх
• Шалгалт өгөх хүний тоо олон байх тохиолдолд	TAI Институт MHRI	Байгууллагаас санал болгосон байр (Тестийг TAI Институтын ажилтан авна)	TAI Институт - Тестэд хамруулах хүсэлт гаргасан байгууллага, хувь хүнд тест бөглөсөн даруйд хариу тайланг цахим шуудангаар илгээх болно.
• Компаниас тестэд хамруулж буй хүний тоо цөөн байх тохиолдолд • Хувь хүн		MHRI Тестийн төв (Хаяг: СБД VI хороо, Их тойруу-49Тулга ХК-ийн байр.. III давхар 300 тоот Утас: 7000-1075, 8000-1075)	




Log-in



- www.talentsassessment.com/assessment
- Хэл сонгоно.
- ID / Password оруулж нэвтэрнэ.

Заавар



- Заавартай танилцана.
- 'Эхлэх' товчийг дарна.

Тест



- Өгөгдсөн өгүүлбэрийг уншаад санал нийлж байвал 'Тийм' үгүй бол
- 'Үгүй' гэсэн хариултаас сонголт хийнэ.

TAI тестийг ашиглахын өмнө 2 төрлийн эрх олгох сургалтанд хамруулах бөгөөд сургалтанд хамрагдсаны дараа чөлөөтэй ашиглах бүрэн эрхтэй болно.

ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ

LV 2.

Мэргэжилтний сургалт

- Мэргэжилтний гарын авлагын сургалт (8цаг)
- Premium тайлан ашиглах боломжтой
- Дэд үзүүлэлтийн оноо өгөгдөнө
- Тайланг ашиглан ярилцлага хийх сургалт



LV 1.

Хэрэглэгчийн сургалт

- Үндсэн гарын авлагын сургалт (3цаг)
- TAIPI худалдаж авах эрх авна
- TAIPI систем ашиглана
- Basic тайлан ашиглана

ХЭРЭГЛЭГЧИЙН ХУУДАС

ID	Personnel	Name	Company	Job	Salary
101010101	2000	Тай	Тай	Тай	10000000
101010102	2000	Тай	Тай	Тай	10000000
101010103	2000	Тай	Тай	Тай	10000000
101010104	2000	Тай	Тай	Тай	10000000
101010105	2000	Тай	Тай	Тай	10000000
101010106	2000	Тай	Тай	Тай	10000000
101010107	2000	Тай	Тай	Тай	10000000
101010108	2000	Тай	Тай	Тай	10000000
101010109	2000	Тай	Тай	Тай	10000000
101010110	2000	Тай	Тай	Тай	10000000

Шинэ төсөл үүсгэх
Төслийг удирдах хянах
Ажил горилогчийг бүртгэх
Ажил горилогч тест бөглөсөн эсэхийг шалгах
АГ-ийн нэвтрэх нэр, нууц үг
Явц: 'Дуусаагүй' эсвэл 'Дууссан'
Тайланг татах
Урьдчилж харах(HTML)
PDF-ээр татах

THE SCIENCE OF PERSONALITY
SELECTION & DEVELOPMENT

TAIPI тестийн оноогоор зан төлөв тус бүрийн сул талыг мэдэх боломжтой бөгөөд ярилцлагын асуулт бэлдэхэд ашиглах боломжтой.

Тайланг ярилцлагад хэрхэн ашиглах вэ?

Тайлбар

01

Тестийн хариу шалгах

• **“Тестийн хариунаас бага оноотой үзүүлэлтүүдийг шалгана.”**

-Тестийн оноо 0-35-аас бол бага, 36-65 хооронд бол дунд, 65-аас их бол өндөр гэж үзнэ.

02

Тодруулах шаардлагатай үзүүлэлтээр гол асуултыг боловсруулах

“35-аас бага оноотой бол үндсэн асуултаа түүнд хамааруулан боловсруулах”

-Ярилцлагын цаг хангалттай бол 50-аас бага оноотой үзүүлэлтүүдийн талаар асуух

03

Энгийн зан төлөв, үл нийцэх зан төлвийн оноог харьцуулж нэмэлт асуулт бэлдэх

“Энгийн зан төлөв болон үл нийцэх зан төлөвийн онцлох шинжих давхацсан порфайлын хувьд нэмэлт асуулт асуух”

-Ярилцлагын асуултуудыг ашиглах зааварт тодорхойлсон онцгой шинж чанарт хамаарах нэмэлт асуултыг ажил горьлогчоос асууна.

04

Зан чанарын онцлог, сул талыг тодорхойлох гүнзгийрүүлсэн асуулт бэлдэх бing асуулт

• **“Тусгай аргаар гол асуултын хариултаа даалж асуух”**

-Нарийвчлан задалж асуухын тулд STAR аргыг ашиглаж болно.

*** STAR Method : Situation, Tasks, Actions, Results**

Situation (нөхцөл байдал) - Нөхцөл байдал ямар байв?

Tasks (даалгавар) - Үг нөхцөл байдалд өгөгдсөн даалгавар юу байв?


Actions (үйлдэл) - Даалгавраа биелүүлэхийн тулд юу хийв?

Results (үр дүн) - Тухайн үйлдлийн үр дүн юу байв?




Тестийн оноо нь стандарт оноо (norm-referenced scoring) байх бөгөөд, TAIPi тестэд ашигласан стандарт нь Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд одоогоор ажил эрхлэж буй иргэдээс авсан судалгааны үр дүн болно.

- Тест өгч буй хүний оноог тусгай бүлэгтэй харьцуулж ажил горилогчийн харьцангуй оноог гаргана. Ихэнхи зан төлвийн тестүүд энэ мэт стандартад харьцуулсан оноог ашигладаг.
- Стандартад харьцуулсан оноо тооцох аргачлал
Тухайн хүний тестийн нийт оноог гаргах (Үндсэн оноо) - Стандарт бүлгийн харьцангуй оноонд хөрвүүлэх



TAIPI тестийн хариу тайлан нь нийт 7 хуудсаас бүрдэх бөгөөд ярилцлага хийхэд шаардлагатай мэдээлмүүдээс бүрдсэн болно.



Хуудас 1

Нүүр

Хуудас 2

Танилцуулга

Хуудас 3

Энгийн зан
төлвийн
нэгдсэн дүн

Хуудас 4

Ажил,
мэргэжилд
тохирох
эсэх
үзүүлэлт

Хуудас 5

Үл нийцэх
зан
төлвийн
нэгдсэн дүн

Хуудас 6

Энгийн зан
төлвийн дэд
үзүүлэлтийн
оноо

Хуудас 7

Үл нийцэх
зан
төлвийн дэд
үзүүлэлтийн
оноо



(9100-3549)



(8000-1075)



Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв II, 6-р хороо, БЗД, УБ
www.talentsassessment.com
orp_mongolia@orp.co.kr
9100-3549

THE SCIENCE OF SELECTION & DEVELOPMENT

Үг танилцуулга нь Talent Assessment Institute-ийн хуулиар хамгаалагдсан оюуны өмч тул зөвшөөрөлгүй хэсэгчлэн
болон бүхэлд нь хуулбарлах, тараахыг хориглоно.